



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/367

Булган сум

“Аялал жуулчлалын эвент арга хэмжээг
зохион байгуулах” зардлын хуваарь батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.7, 23.1.9, дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө батлуулах тухай” XIII/02 тогтоол, 2023 оны хуралдааны XIX/08 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан “Аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах” төсөл арга хэмжээний зардлын 220,000,000 (хоёр зуун хорин сая) төгрөгийг хавсралтаар баталсугай.
2. Хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т тус тус үүрэг болгосугай.
3. Батлагдсан төсөл, арга хэмжээний зардлыг хууль журмын дагуу санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 21-ны ний өдрийн 7/36 дугаар
захирамжийн хавсралт



“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ”
ЗАРДЛЫН ХУВААРЬ

д/д	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (сая төгрөг)	Хүрэх үр дүн
1	2	3	4
1	“1 жуулчин – 1 хонь” төсөл хөтөлбөрийг аймгийн хэмжээнд зохион байгуулах	21,000.0	"Монгол Улсын Засгийн газар 2023-2025 оныг Welcome to Mongolia болгон зарласантай холбогдуулан Монгол улсын Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас санаачлан өвлийн аялал жуулчлалыг дэмжих зорилгоор мал аж ахуйг түшиглэсэн, нутгийн иргэдийн оролцоонд тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, малчин ахуй соёлыг дэлхийд сурталчилах, малын гаралтай бүтээгдэхүүнийг экспортлох, аймгийн эдийн засгийн тэлнэ.
2	“Хангинахын шугуйн шагайн тойром”-ын эвент арга хэмжээг зохион байгуулах	15,000.0	Булган аймгийг зорин ирэх аялагч жуулчдыг татаж нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал хөгжинэ.
3	“Айрагны баяр” эвент арга хэмжээг зохион байгуулах	144,000.0	Булган аймгийг зорин ирэх аялагч жуулчдыг татаж нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал хөгжинэ.
4	“Айраг өдөр” намрын үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	30,000.0	Булган аймгийг зорин ирэх аялагч жуулчдыг татаж нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал хөгжинэ.
5	Олон Улсын “ITM-2024” аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох	10,000.0	Булган аймгийн аялал жуулчлалыг олон нийтэд сурталчилна.
Нийт дүн		220,000.0	